

# ИРГЭД, ХАМТРАН АЖИЛЛАГЧ ТАЛУУД БОЛОН БАЙГУУЛЛАГЫН АЖИЛЧДААС ДЭЛХИЙН БАЙГАЛЬ ХАМГААЛАХ САН (WWF)-ГИЙН МОНГОЛ ДАХЬ ХӨТӨЛБӨРИЙН ГАЗАРТ ХАНДАЖ

## ӨРГӨДӨЛ, ГОМДОЛ ГАРГАХ ЗАРЧИМ

ӨРГӨДӨЛ,  
ГОМДОЛ  
ГАРГАХДАА:



- Бичгээр,
- Цахим хэлбэрээр,
- Биечлэн гаргана.

Өргөдөл, гомдолд дараах мэдээллийг заавал дурдсан байна. Үүнд:

- Өргөдөл, гомдол гаргагчийн овог нэр, холбоо барих мэдээлэл;
- Өргөдөл, гомдлыг өөрөө гаргаагүй тохиолдолд түүнийг төлөөлөн гомдол гаргаж байгаа этгээд төлөөлөх эрхтэй болохоо нотолсон нотолгоо /итгэмжлэл/;
- Өргөдөл, гомдлын талаарх мэдээлэл;
- Бусад холбогдох бичиг баримт болон мэдээлэл;
- Нууцлах шаардлагатай эсэх (шалтгааныг дурдах).

ӨРГӨДӨЛ,  
ГОМДЛЫГ ХҮЛЭЭН  
АВАХДАА:



- Дэлхийн байгаль хамгаалах сан (WWF)-гийн Монгол дахь хөтөлбөрийн газрын захиралд
  - +976-11-318447 дугаарын утсаар,
  - batbold@wwf.mn цахим хаягаар,
  - Албан ажлын байран дээрээ хүлээн авна.

ӨРГӨДӨЛ,  
ГОМДЛЫГ ХЯНАН  
ШИЙДВЭРЛЭХДЭЭ:



- Өргөдөл, гомдлыг хүлээн авсан өдрөөс хойш 30 хоногт багтаан шийдвэрлэнэ.
- Шууд шийдвэрлэх боломжтой өргөдөл, гомдлыг ажлын 3 хоногт зохих хариуг өгнө.
- Шууд шийдвэрлэх боломжгүй, хугацаа шаардах, хамаарах асуудлаар дээд шатны байгууллагаас чиглэл авах шаардлагатай өргөдөл, гомдол гаргагчид эцэслэн хариу өгнө.
- Өргөдөл, гомдлыг шийдвэрлэсэн хариуг
  - амаар буюу харилцах утсаар,
  - цахим сүлжээгээр эсхүл
  - бичгээр зэрэг тохиромжтой хэлбэрээр мэдэгдэнэ.

ӨРГӨДӨЛ, ГОМДОЛ  
ГАРГАГЧ НЬ  
ДАРААХ ЗҮЙЛСИЙГ  
ЭРХЭМЛЭНЭ. ҮҮНД:



- Өргөдөл, гомдол гаргагч нь ёс зүйн хэм хэмжээ, харилцааны соёлыг эрхэмлэн өргөдөл, гомдлоо гаргана.
- Өргөдөл, гомдол гаргахдаа хүний нэр төр, алдар хүндэд халдах, гутаах, гутгэх, доромжлох зэрэг худал өргөдөл, гомдол гаргасан нь тогтоогдвол Монгол улсын хууль болон бусад хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.